

# МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 24/5

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2024 оны 12 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний өдөр мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засаг, банкны секторын өнөөгийн байдлын талаар Монголбанкны хариуцсан газрууд танилцууллаа. Хуралдааны дараагийн өдөр эдийн засгийн цаашдын төлөв, мөнгөний бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хурлын эхний хэсэгт Санхүүгийн зах зээлийн газар (СЗЗГ)-аас мөнгөний бодлогын хэрэгжилт болон зах зээлд гарсан өөрчлөлтүүдийн талаар танилцууллаа. Нүүрсний экспортын орлого 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 8.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 200 орчим сая ам.доллаар нэмэгдсэн. Улаанбаатар хотын бонд, Голомт банкны бондууд нь гадаад валютын орох урсгалыг дэмжив. Нөгөө талдаа, машин, механизмын тоног төхөөрөмж, суудлын автомашин, үйлчилгээний импорт нэмэгдсэнээр гарах урсгал мөн өсөж, гадаад валютын цэвэр урсгал өмнөх оны мөн үеэс 570 орчим сая ам.доллаар буурсан байна. Гадаад валютын улсын нөөцийн хэмжээ 11 дүгээр сарын байдлаар 4.9 тэрбум долларт хүрч, импортын 4.9 сарын хэмжээг хангах дүнтэй байна. Үргэлжлүүлэн мөнгөний захын үйл ажиллагаа, банк хоорондын захын арилжааны талаар танилцуулав.

Банкны системд гарсан өөрчлөлтүүд, өнөөгийн байдлын талаар Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (ББӨБГ)-аас танилцууллаа. Банкны системийн нийт актив 2024 оны 3 дугаар улиралд 26.7 хувиар өсөж, 62.4 их наяд төгрөгт хүрч нэмэгдлээ. Үүнд зээл болон ТБҮЦ-ны өсөлт голлон нөлөөлөв. Нөгөө талаас, банкны системийн нийт пассив 55.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өссөн ба үүнийг харилцах болон хадгаламжийн өсөлт голчлон бүрдүүлсэн байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зээлд эзлэх чанаргүй зээл 5.1 хувь, анхаарал хандуулах зээлийн харьцаа 3.6 хувьд хүрсэн нь 2015 оноос хойших хамгийн бага түвшин болсныг онцлов.

Сүүлийн өдрийн хуралдаанд МБГ-аас мөнгөний бодлогын саналыг эдийн засгийн суурь төсөөлөл, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, хувилбар төсөөллүүдэд үндэслэн танилцуулав.

Инфляц 2024 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 8.1 хувьд хүрч өмнөх сараас 1.1 нэгж хувиар нэмэгдлээ. Үүний 1.3 нэгж хувийг өрхийн цахилгааны үнийн өсөлт дангаараа тайлбарлаж байгааг онцлов. Инфляцын цаашдын төлөвийн хувьд цахилгаан, ус суваг, дулаан зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн шууд болон дам нөлөөнөөс гадна, төсвийн тэлэлт, эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаанаар инфляц эрчимжиж, ирэх онд зорилтын дээд хязгаарыг давж өсөхөөр байгааг танилцуулав. Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил буурч, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөө арилах, гадаад инфляц саарах зэргээс шалтгаалан инфляц буурч, 2026 онд зорилтын интервалд орж тогтворжих төсөөлөлтэй байгааг танилцууллаа.

Энэ оны эхний 3 улиралд эдийн засаг 5.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын идэвхжил, үйлчилгээний салбарын өсөлт голлон бүрдүүлж байна. Цалин, өрхийн орлогын өсөлт, импортын тэлэлт зэрэгтэй

холбоотойгоор бүтээгдэхүүний цэвэр татвар эдийн засгийн өсөлтийн 2.0 орчим хувийг бүрдүүлжээ. Харин өнгөрсөн өвлийн цаг агаарын таагүй нөхцөлийн улмаас хөдөө аж ахуйн салбар 25 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтөд 3.5 нэгж хувийн бууруулах нөлөөг үзүүллээ. Эдийн засаг энэ онд 5.2 хувиар өсөх төсөөлөлтэй байгааг танилцууллаа. Энэ оны 3 дугаар улиралд уул уурхайн салбарын гүйцэтгэл хүлээлтээс бага гарсан ч оны сүүлийн улиралд эргэн сэргэснээр энэ онд 13.3 хувиар өсөх хүлээлттэй байна. Уул уурхайн бус салбарын хувьд цалин, өрхийн орлогын өсөлт нь үйлчилгээний салбарыг дэмжих, мөн импорт, өрхийн хэрэглээний тэлэлтээс шалтгаалан бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт сайн байж энэ онд 4.0 хувиар, ХАА-н салбарыг хасаж тооцвол 9.0 орчим хувиар өсөх төсөөлөлтэй байна. Ирэх онд нүүрсний олборлолт өндөр түвшинд хадгалагдаж, Оюутолгойн үйлдвэрлэл эрчимжсэнээр уул уурхайн салбарын идэвхжил нэмэгдэх, төсвийн төлөв сулрах, хөрөнгө оруулалтууд нэмэгдэх зэрэг нь уул уурхайн бус салбарыг тэтгэж, эдийн засаг 7.5 хувиар өсөхөөр байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2024 оны эхний 10 сард 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Эдийн засгийн идэвхжил, гадаад худалдааны эргэлт, цалингийн өсөлттэй холбоотойгоор татварын орлого бүрдүүлэлт өндөр байж нийт тэнцвэржүүлсэн орлого 23.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26 хувиар өсжээ. Төсвийн зардлын хувьд эхний 10 сарын байдлаар 22.3 их наяд төгрөг буюу 82 хувийн гүйцэтгэлтэй байв. Харин мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 10 дугаар сард 25.1 хувьд хүрч буурахад төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор гадаад цэвэр активын хэмжээ буурсан нь голлон нөлөөлжээ. Нийт зээлийн үлдэгдлийн хувьд 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өссөнөөс хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл 37.0 хувиар, бизнесийн зээл 31.3 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Эхний 9 сарын байдлаар төлбөрийн тэнцэл 251 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Хэдийгээр нүүрсний экспортын биет хэмжээ өндөр түвшинд хадгалагдаж байгаа хэдий ч үнэ буурах хандлагатай, импортын өсөлт өндөр байгаа зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцэл ийнхүү алдагдалтай гарах хүчин зүйл боллоо. Цаашдын төлөвийг авч үзвэл, нүүрс, алт, зэс зэрэг түүхий эдүүдийн үнэ буурах, импортын өсөлт өндөр байх зэргээс шалтгаалан өмнөх төсөөллөөс муудахаар байна.

Мөнгөний бодлогын газрын зүгээс инфляц, эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод орчны нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах; банкны төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, харгалзан 11 хувь болон 16 хувьд хүргэх бодлогын саналыг дэвшүүлэв. Улмаар, МБХ-ны гишүүд асуулт асуун, тодруулга авч бодлогын саналыг хэлэлцлээ.

Нэг гишүүний хувьд төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны талаар асууж тодрууллаа. Ирэх онд Засгийн газар, арилжааны банкуудын гадаад зээлийн ашиглалт нэмэгдэх, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу томоохон төлбөр байхгүй зэргээс шалтгаалан санхүүгийн дансанд дарамт харьцангуй бага байхаар төсөөлөлтэй байгааг танилцуулав.

Өөр нэг гишүүний зүгээс 2026 онд үйлдвэрлэлийн зөрүүний буурах шалтгааныг тодрууллаа. Үүнд, 2025 онд Оюу толгойн зэсийн баяжмалын алт, зэсийн агууламж өссөнөөр уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэх, төсвийн төлөв суларч, хөрөнгийн орох урсгалын нэмэгдэх нөлөөгөөр үйлдвэрлэлийн зөрүү нэмэгдэхээр байна. Харин 2026 оноос эдгээр эерэг нөлөөллүүд арилах, худалдааны нөхцөл, гадаад эрэлт муудах зэргээс шалтгаалан нийт үйлдвэрлэл потенциал түвшнээс бага зэрэг доогуур түвшинд хүрч

буурах төсөөлөлтэй байгааг танилцууллаа. Түүнчлэн, дунд хугацааны суурь төсөөллийн таамаглалд Засгийн газар (ЗГ)-аас хэрэгжүүлэх томоохон мега төслүүдийг тусгаагүй бөгөөд эдгээр төслүүд хэрэгжих нь үйлдвэрлэлийн зөрүүг нэмэгдүүлэх нөлөөтэйг дурдав.

Өөр нэг гишүүний хувьд эдийн засгийн өсөлт дунд хугацаанд хүлээлтээс өндөр гарах буюу эерэг чиглэлд нөлөөлөх эрсдэл, тодорхой бус байдал байгаа гэдэгтэй санал нэг байгаагаа илэрхийллээ. Тодруулбал, ЗГ-аас хэрэгжүүлэх мега төслүүдээс гадна нийслэлээс хэрэгжүүлэх томоохон төслүүд нь эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байгааг дурдав. Уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэхийн зэрэгцээ уул уурхайн бус салбар сайжирч, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт эрчимжих эрсдэлтэй, мөн гадаад орчны эрсдэл тодорхой бус байдал өндөр байгааг онцлов.

Улмаар, МБХ-ны гишүүдийн хувьд зээл, санхүүжилтийн нөхцөлийг хэт хатууруулахгүй байж, дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах зорилгоор бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах саналыг дэмжив.

Цаашлаад банкны төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийг нэмэгдүүлэх саналыг хэлэлцлээ.

МБХ-ны гишүүд зээлийн өсөлт өндөр түвшинд хэвээр байгаа нь инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлах шалтгаан болж болзошгүй байгаатай санал нэгтэй байв. Тодруулбал, цалингийн өсөлтийг дагасан хэрэглээний зээлийн өсөлт, засгийн газраас хөнгөлөлттэй зээлүүдийг олгож байгаа зэрэг нь эрэлтийн сувгаас гадна импортыг тэтгэж, төлбөрийн тэнцлийг муутгаснаар ханшаар дамжин инфляцыг өсгөх эрсдэлтэй. Түүнчлэн, нийт зээлийн үлдэгдэл ДНБ-ий харьцаа нь урт хугацааны хандлагаасаа өндөр, санхүүгийн мөчлөгийн сөрөг зөрүү энэ оны эхнээс хаагдаж, эерэг болсон зэрэг нь зээлийн нөхцөлийг чангаруулах шаардлагыг нэмэгдүүлж байна. Мөн ТБҮЦ-ны үлдэгдэл нь сүүлийн 4 сар буурсан хэдий ч өндөр хэвээр байгаа зэргийг харгалзан санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлж, тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор төгрөгийн болон гадаад валютын эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлэх бодлогын саналыг 100 хувь дэмжлээ.

Ийнхүү Мөнгөний бодлогын хорооны 4 дүгээр улирлын ээлжит хурал өндөрлөв.

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 12 дугаар сарын 12, 13-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах;
2. Банкнуудын төгрөгийн болон гадаад валютын эх үүсвэрийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж, харгалзан 11 хувь болон 16 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ.

### Бодлогын саналын шийдвэр

